



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 10 сарын 16 өдөр

Дугаар А/659

Булган сум

Татварын хуулийн хэрэгжилтийг хангах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.10, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Татварын ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 26.2, 26.3, 26.4 дахь хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь.

1.Булган аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй татвар төлөгч хувь хүн, хуулийн этгээдийг газар зүйн мэдээллийн системд суурилсан газар, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл, үнэлгээ, татвар, төлбөрийн нэгдсэн системийг хөгжүүлэх суурь судалгааны мэдээлэл цуглуулах, татвар төлөгчид татварын хууль тогтоомжийн талаар сурталчилгаа, зөвлөгөө өгөх, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих замаар далд эдийн засгийг илрүүлэх, бүртгэлжүүлэх, улс, аймаг, сумын төсвийн орлогын нэмэлт эх үүсвэр бий болгох, татварын орлогын төлөвлөгөөг ханган биелүүлэх зорилгоор “Татвар төлөгчийн шинэчилсэн бүртгэл, тооллого”-ыг батлагдсан удирдамжийн дагуу зохион байгуулахыг аймгийн Татварын газар (Д.Лхагвасүрэн)-т даалгасугай.

2.Аймгийн хэмжээнд газрын бүртгэл, ногдлын мэдээллийн зөрүүг арилгах, шүүхийн маргааныг эцэслэн шийдвэрлүүлэх, өмчилсөн газрын татварын ногдлыг холбогдох мэдээллийн санд үүсгэхийг аймгийн Татварын газар (Д.Лхагвасүрэн), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн), Байгаль орчны газар (А.Гантөмөр), Улсын бүртгэлийн хэлтэс (Ж.Ганболд)-т тус тус үүрэг болгосугай.

3.Аймаг, сумын төсөвт төвлөрүүлэх татварын өрийн үлдэгдлийг татварын хууль тогтоомжийн хүрээнд хураан барагдуулах, аймаг, сумын төсвийн татварын орлогыг нэмэгдүүлэх, татварын бааз суурийг өргөтгөх чиглэлээр тодорхой ажил зохион байгуулахыг Татварын газар (Д.Лхагвасүрэн)-т даалгасугай.

4.Татвар төлөгчийн бүртгэл, тооллого, хяналт, өр хураах үйл ажиллагааг зохион байгуулахад шаардагдах хавсралтаар батлагдсан зардлын 1,598,800 (нэг

6325010922

сая таван зуун найман мянга найман зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Эрдэнэбилэг)-т зөвшөөрсүгэй.

5.Энэхүү захирамжид заасан ажлыг зохион байгуулах удирдамж, нарийвчилсан төлөвлөгөө, тооллогын маягт гарган хэрэгжилтэд хяналт тавихыг Аймгийн Засаг даргын тамгын газар (Д.Эрдэнэбилэг)-т, бүх төрлийн дэмжлэг үзүүлж ажиллахыг аймаг, сумын нутгийн захиргааны байгууллагын дарга болон сумдын засаг дарга нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

Аймгийн Засаг даргын 2025 оны
10 дугаар сарын 16-ны/ний өдрийн
А/659 дугаар захирамжийн хавсралт



СУМДАД АЖИЛЛАХ ШАТАХУУНЫ ТООЦОО

Д/д	Сумын нэр	Ирж, очих км	Зарцуулах шатахуун /л/	Алсын багуудад шатахуун /л/	Нийт Зарцуулагдах шатахуун /л/	1л шатахууны үнэ	Мөнгөн дүн
1	2	3	4	5	6	7	8
1	Булган-Хутаг-Өндөр	150	30	50	80	2720	217,600.00
	Хутаг-Өндөр-Хонгор	45	10	20	30	2720	81,600.00
	Хонгор-Булган	195	40		40	2720	108,800.00
2	Булган-Хишиг-Өндөр	70	15	30	45	2720	122,400.0
	Хишиг-Өндөр-Булган	70	15		15	2720	40,800.00
3	Булган-Орхон	22	5	20	25	2720	68,000.00
	Орхон-Булган	22	5		5	2720	13,600.00
	Булган-Орхон сум Бүрэнбүст (аялал жуулчлал)	55	10	30	40	2720	108,800.00
	Бүрэнбүст-Булган	55	10		10	2720	27,200.0
Нийт дүн		684	140	150	290	2720	788,800.00

СУМДАД АЖИЛЛАХ ТОМИЛОЛТЫН ЗАРДАЛ

Д/д	Сумын нэр	Ажиллах хүний тоо	Хоногийн тоо	Томилолтын зардал /төгрөг/	Нийт дүн /төгрөг/
1	2	3	4	5	6
1	Хутаг-Өндөр	3	1	90,000.00	270,000.00
2	Хишиг-Өндөр	3	1	90,000.00	270,000.00
3	Орхон	3	1	90,000.00	270,000.00
Нийт дүн		21	12		810,000.00